

Буянт сумын байгальд ээлтэй сургууль



Уриа: “Цэнгэг ус, цэлмэг тэнгэр, цэцэг навч, цэвэр орчин бидний ирээдүй”

- 1. Түүхэн замнал :** Манай сургууль 1936 онд Буянт сумын бага сургууль нэртэй анх байгуулагдсан. 1981 онд 8 жилийн сургууль, 1994 онд 10 жилийн сургууль, 1996 онд Лааганы нэрэмжит сургууль, 2005 онд 11 жилийн сургууль, 2008 оноос 12 жилийн сургууль болсон бөгөөд 1996 онд МУ-ын засгийн газрын 242 тоот тогтоолоор Төр нийгмийн нэрт зүтгэлтэн Улсын бага хурлын дарга Л.Лааганы нэрэмжит болсон билээ. Өнөөдөр тус сургуульд 482 суралцагч, 40 гаруй багш, ажилчид ажиллаж байна.
- 2. Байгальд ээлтэй сургууль:** 2007 онд энэ төсөлд хамрагдсан. Хүүхэд болон иргэдийн байгальд хандах хандлагад өөрчлөлт оруулах талаар их зүйл хийж байгаа нь ач холбогдол өгч байна. Одоо манай сургуулийн багш, сурагчдын зохион байгуулж байгаа ямар ч ажилд заавал байгалиа хамгаалах хайрлах чиглэлийн асуудал орж байгаа нь төслийн үр дүн гэж үзэж байгаа юм.
Үүнээс өмнө “Ногоон сургууль” төсөл хэрэгжиж байсан.

Нэгдүгээр алхам: Эко зөвлөл байгуулах

Манай эко зөвлөл 21 хүний бүрэлдэхүүнтэй. Даргаар нь сургуулийн захирал Ж.Батмөнх, нарийн бичгийн даргаар нь сургалтын менежер Т.Жаргалсайхан нар ажилладаг. Эко зөвлөлд захирлын зөвлөлийн гишүүд, багш нар, сурагчдын үүсгэл санаачлагын байгууллагын дарга нар, эцэг эхийн төлөөлөл, сайн дурын холбооны гишүүд орсон байдаг.

Эко зөвлөл нь улирал 1 удаа хуралдаж ажлаа сар, улирал, жилээр төлөвлөж гүйцэтгэлд нь сургуулийн удирдлагууд хяналт тавин ажилладаг

Хоёрдугаар алхам: Сургуулийн дотоод, гадаад орчныг үнэлэх

Сургуулийн дотоод орчны үнэлгээг багш нар сурагчидтайгаа хамтран хийж дүгнэлт гаргасан.

- Ангиудын хог хаягдалын хэмжээ багассан
- Ангиудын дулаан тогтворжсон
- Анги танхимын тоосжилт багассан гэсэн дүгнэлт гарч байгаа
- Сургуулийн дотуур байрны сурагчдын усны хэрэглээ ихэссэн, халуун ус, дотор ОО-той болсон
- Модон түлшний хэрэглээ үгүй болсон
- Цахилгаан энергийн хэрэглээ нилээд өндөр болсон байна.

Нүүрсний зарцуулалт ихэссэн энэ халаах талбай нэмэгдсэнтэй холбоотой.

Íèèð àààø íàð àíèíí àóíà àðèàð àíàèéí ñòðàà÷-èà àíàè ñòðàóóèèéí àýðýèðçìýà, áòèàáí, òííñæèðííä çíýèäýý òèèð ÷àààððàè àíèñíí ò°àèèäçé æèèà 1 óààà çíýèäýý òèèæ ààéíà. Àíàè áçðýí àíàèàà ààèààèèéí áòèàíðàè àíèñííí.

Гуравдугаар алхам: Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах

Эко код, лого, уриа: “Цэнгэг ус, цэлмэг тэнгэр, цэцэг навч, цэвэр орчин бидний ирээдүй”

3. **Тэргүүн туршлага:** Байгальд ээлтэй сургууль төсөл нь манай сургууль дээр 2007 оноос эхлэн 4 дэх жилдээ амжилттай хэрэгжиж байна. Энэ хугацаанд төслийн зүгээс мэдээлэл харилцааны иж бүрэн техник хэрэгсэл, мэдээллийн сан бүрдүүлж өгсөн нь бидний үйл ажиллагаагаа явуулахад ихээхэн ач холбогдол өгч байна.



Мөн манай сургуулийн багш нар өөрсдийн санал санаачлагаар сургуулийн жилийн ажлын төлөвлөгөөнд төслийн үйл ажиллагаа руу чиглэсэн нэг нэг ажил төлөвлөдөг ба түүнийг нь “Бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ”-нд тусгаж өгдөг. Ингэснээр тухайн ажлын бодит үр



дүнг тооцох хөшүүрэг болдог. Үүнийхээ үр шимийг тодорхой хэмжээнд хүртэх боломжтой гэсэн үг юм.